

## Гачуурт тосгоны хүн эмнэлэг

Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1961 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 105 дугаар захирамжаар Гачууртын САА-г түшиглэн 8 ортой хүний их эмчийн салбар нэртэйгээр байгуулагдан их эмч 1, бага эмч 1, сувилагч 1 орон тоотой байсан.

1988 онд ЭХЯ, хотын Эрүүл мэндийн газрын шийдвэрээр 15 ортой Гачуурт тосгоны хүн эмнэлэг нэртэйгээр өргөжсөн.

Тус с эмнэлэг нь түүхэн 47 жилийн хугацаанд НҮБ-н Хүүхдийн сангийн "Хүүхдэд ээлтэй эмнэлэг" Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүний байгууллага, 1990 оны БЗД-ийн тэргүүний байгууллага, 1995 оны тосгоны шилдэг хамт олон болж байсан. Эхийн эндэгдэл гаргаж байгаагүй, сүүлийн 10 жилд хүүхдийн эндэгдэл гараагүй.

### **Үйл ажиллагааны чиглэл:**

1. Стационарын тусламж үйлчилгээ-дотрын 13, хүүхдийн 2 ортой сумын эмнэлгийн анхан шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг.

2. Алсын дуудлага-Улиастай, Гүнжийн хоолой, Шар хоолой, Их ам, Бага ам, Арцат, Могойт дэнж, Бага хуандай, Их хуандай, Дээндий, Хар усан тохой, гэсэн чиглэлүүдэд тусламж үзүүлдэг.

3. Яаралтай тусламж-ажлын бус цагаар болон баяр ёслолын өдрүүдэд дуудлагаар тосгоны хүнд амд үйлчилдэг

### **Эмнэлгийн удирдлагууд:**

Д.Уламбаяр 1962-1986 салбарын эрхлэгч

Б.Готов 1986-1987 салбарын эрхлэгч

Б.Дэчинлхам 1987-1989 салбарын эрхлэгч

Ц.Батсүх 1989-2004 ерөнхий эмч

Д.Цолмон 2004 оноос хойш ерөнхий эмч

Барилга байгууламж :

Тус эмнэлгийн одоогийн барилга 1961 онд хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар ашиглалтанд орсон. 1963 оноос эмнэлгийн зориулалтаар ашиглаж байна. 361 м2 талбайтай. Хэвтэн эмчлүүлэх 7 өрөө, эмчийн 2 өрөө, эмийн агуулах, аж ахуйн агуулах, архив, сувилагчийн өрөө, чийрэгжүүлэхийн өрөө, гал тогоо, угаалга, халуун ус бие засах газартай.

### **Тоног төхөөрөмж:**

1. Сумын эмнэлгийн стандартын дагуу байх шаардлагатай багаж хэрэглэлүүд

2. ЭХО аппарат

3. Зүрхний бичлэгийн аппарат

4. Хүчилтөрөгчийн коктейлийн иж бүрдэл

5. Чийрэгжүүлэхийн 7 төрлийн тоног төхөөрөмж

6. Компьютер-2 Автомашин УАЗ-469 1 авто машинтай

**Хүний нөөц:**

Тус эмнэлэг нь нийт 20 ажиллагсадтай. Үүнээс их эмч -2, бага эмч 4, сувилагч -4, асрагч -4, нягтлан-1, нярав -1, тогооч- 1, жолооч -1, угаагч ариутгагч -1, слесарь -1, ажиллаж байна.

Хамт олны дунд Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан -2, ЭМЯ-ны жуух бичгээр шагнагдсан 5, олон нийт байгууллагын шагналтан 8, Тосгоны ажил хөдөлмөрийн аварга -5, анагаах ухааны магистр -1 ажилладаг.